

Монгол улс

**ГААЛИЙН БИЕТ ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХЭТ ИХ
БАЙГАА АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ БУЮУ
БУУРУУЛАХ**

Барбара Хеберт, Ёошикази Сакай



Техникийн Тайлан

2022 оны 3 дугаар сар

Энэхүү тайлан нь Монгол улсын эрх бүхий байгууллага (цаашид "ТТ хүлээн авагч тал" гэх)-ын зүгээс техникийн туслалцаа авах хүсэлтийн дагуу Олон улсын валютын сан (ОУВС)-гийн мэргэжилтнүүдээс өгсөн техникийн зөвлөгөө, зөвлөмжийг агуулсан болно. ТТ хүлээн авагч талаас тусгайлан тараан түгээхээс татгалзахаас бусад тохиолдолд энэ тайланг бүрэн хэмжээгээр эсхүл хэсэгчлэн эсхүл түүний хураангуйг ОУВС-гийн Гүйцэтгэх захирлууд болон ажиллагсад, ТТ хүлээн авагч талын харьяа болон бусад байгууллагууд, мөн Дэлхийн банкны ажиллагсад, техникийн туслалцаа үзүүлэгч бусад байгууллага болон хууль ёсны ашиг сонирхол бүхий хандивлагчдад тэдгээрийн хүсэлтийн дагуу тарааж болно (Техникийн туслалцааны мэдээллийг тараах талаар дараах Үйл ажиллагааны заавраас авна уу: <http://www.imf.org/external/np/pp/eng/2013/061013.pdf>).

Иймд энэ тайланг (бүрэн хэмжээгээр эсхүл хэсэгчлэн) эсхүл түүний хураангуйг ТТ хүлээн авагч талын харьяа болон бусад байгууллагууд, Дэлхийн банк, техникийн туслалцаа үзүүлэгч байгууллагууд болон хууль ёсны ашиг сонирхол бүхий хандивлагчдаас бусад ОУВС-д хамааралгүй гаднах талуудад ил болгох бол ТТ хүлээн авагч тал болон ОУВС-гийн Төсвийн асуудал эрхлэх газраас зөвшөөрөл авах шаардлагатай.

Энэхүү техникийн туслалцааг (ТТ) Япон улсын засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр үзүүлсэн болно.

I. ОРШИЛ

1. Энэхүү тайланд ОУВС-гийн Төсвийн асуудал эрхлэх газар (ТАЭГ) -ын эксперт Барбара Хеберт, Ёошикази Сакай нарын чадавхыг хөгжүүлэх (CD) чиглэлээр 2021 оны 10-р сарын 25-наас 11-р сарын 26-ны хооронд ажиллахдаа гаргасан дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэн тусгав. Энэ ажлын зорилго нь импортын мэдүүлгийн 80 гаруй хувьд биет үзлэг шалгалт хийж байгааг 2024 оны эцэст 40 хувь болгон бууруулах Гаалийн ерөнхий газрын дунд хугацааны стратегийн зорилтыг биелүүлэхэд болон биет үзлэг шалгалт хэт их байгааг бууруулахад оршино.

II. ОЛЖ ТОГТООСОН ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖИЙН ХУРААНГУЙ

A. Биет үзлэг шалгалтыг бууруулах үйл явцын ахиц дэвшилт

2. Өмнөх жилүүдийн статистик тоон мэдээллийг харахад биет үзлэг шалгалтын тоо хэт өндөр хэвээр байсан бөгөөд бага зэрэг сайжирсан үзүүлэлт ажиглагдсан болно. 2021 онд 10-р сарын байдлаар импортын мэдүүлгийн 80-аас дээш хувьд биет үзлэг хийгдсэн байна. 2018 оноос хойш сайжирсан үзүүлэлт маш бага бөгөөд ГЕГ-ын дунд хугацааны зорилтод хүрэхэд хол байна. Хүснэгт 1-т 2018-2021 оны хяналтын төлөвүүдийн нөхцөл байдлыг харуулав. (Үүнд: Улаан төлөв- биет үзлэг эсвэл лабораторийн шинжилгээ, шар төлөв- баримт бичгийн шалгалт, ногоон төлөв- хяналт хийхгүй гэдгийг тэмдэглэнэ.)

Хүснэгт 1. Хяналтын төлөвүүд (импорт/экспортын мэдүүлгийн тоонд эзлэх хувь)

	2018	2019	2020	2021-10-р сар
Импорт				
Улаан	87.5	86.3	85.8	84.2
Шар	10.0	12.5	12.8	14.4
Ногоон	2.5	1.2	1.3	1.4
Экспорт				
Улаан	21.4	19.2	21.6	24.9
Шар	32.9	37.7	39.6	40.8
Ногоон	45.7	43.1	39.1	34.3

(Эх сурвалж: ГЕГ)

B. Биет үзлэгээр орох мэдүүлгийг хэрхэн сонгодог талаар

3. ГЕГ-ын систем нь сонголт буюу шигшилт хийхдээ урьдчилан тогтоосон 7 төрлийн эрсдэлийн бүлгээр ангилж, 3 хяналтын төлөвт хуваарилах зарчмаар

ажилладаг. Импорт, экспортын мэдүүлэг нь CEPS системээр дамжин CAIS системээр шалгагддаг. Хүснэгт 2-т эрсдэлийн бүлгүүдийг харуулсан болно.


Хүснэгт 2. Эрсдэлийн бүлэг

Импорт	
FSTIC	First import companies/ Анхны импортын ААН
FSTIG	First import goods/ Анх удаа импортлогдож буй бараа
MI	Mandatory examination import, i.e., set by rules and regulations/ Заавал шалгах (импорт)
HI	High risk import/ Өндөр эрсдэлтэй (импорт)
EI	Exceptional import from MI/ Үл хамаарах (импорт)
LI	Low risk import Бага эрсдэлтэй (импорт)
RI	Unknown risk import, i.e., none of above applied, namely "random"/ Санамсаргүй (үл мэдэгдэх буюу дээрх ангиллуудад хамараахгүй)
Экспорт	
ME	Mandatory examination export, i.e., set by rules and regulations/ Заавал шалгах (экспорт)
HE	High risk export/ Өндөр эрсдэлтэй (экспорт)
EE	Exceptional export from ME/ Үл хамаарах (экспорт)
LE	Low risk export/ Бага эрсдэлтэй (экспорт)
RE	Unknown risk export, i.e., none of above applied, namely "random"/ Санамсаргүй (үл мэдэгдэх буюу дээрх ангиллуудад хамараахгүй)

(Эх сурвалж: ГЕГ)

4. Импортын мэдүүлгийг 7 эрсдэлийн бүлэгт ангилахдаа 13 шалгуур үзүүлэлтээр тооцоолно. Шалгуур үзүүлэлтэд барааны ангиллын код, худалдаа эрхлэгчийн дугаар болон тэдгээрийн хослол багтана. Схем 1-т одоогийн ГЕГ-ын импортын мэдүүлгийг шалгах буюу скрининг хийх процессийг харуулав.

Схем 1. ГЕГ-ын импортын мэдүүлгийг шалгах процесс



5. Импортын мэдүүлгийг шалгах одоогийн процессын үр дүнд биет үзлэг шалгалтын тоо хэт өндөр гарч байгаа буюу заавал шалгах (MI), өндөр эрсдэлтэй HI) болон тогтоогдоогүй эрсдэлтэй (RI) гэсэн 3 ангилалд хуваарилагдаж байна.

Хүснэгт 3-т импортын мэдүүлгийн тоог эрсдэлийн бүлгийн ангилал болон хяналтын төлөвөөр харуулав. Биет үзлэгийн тоог бодитоор бууруулахын тулд MI, HI, RI гэсэн бүлгүүдэд дүн шинжилгээ хийх шаардлагатай. Санамсаргүй түүврээр сонгох ангиллыг ГЕГ нь олон улсад ашиглагддаг нэр томъёоноос өөр утгаар ашигладаг бөгөөд үүний талаардараагийн бүлэгт авч үзэх болно.

Хүснэгт 3. Хяналтын төлөв тус бүрээр импортын мэдүүлгийн сонголтын бүлэг тус бүрт эзлэх хувь (Нийт импортын мэдүүлэгт эзлэх хувиар)

	Total/Нийт	FSTIC	FSTIG	MI	HI	EI	LI	RI
Red/Улаан	84.2	3.9	0.0	39.0	31.0	0.2	0.0	10.1
Yellow/Шар	14.4	0.0	0.0	0.0	0.3	0.2	0.2	13.7
Green/Ногоон	1.4	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.1	1.2

(Эх сурвалж: ГЕГ, 2021 оны 1-ээс 10-р сарын байдлаар)

6. Биет үзлэгээр илрүүлсэн зөрчил, залилангийн тоо бага буюу илрүүлэлтийн түвшин бага байгаа нь одоогийн биет үзлэгийн тоо хэт их байгааг харуулж байна. ГЕГ-ын өгсөн мэдээнээс харахад “улаан” төлөвөөс илэрсэн залилан 0.0 хувьтай, “шар” төлөвөөс 0.6 хувь, “ногоон” төлөвөөс 0.1 хувьтай байна. Энэ нь дараах нөхцөл байдлуудын аль нэг эсвэл нэгдэл байгааг илтгэж байна. Үүнд:

- Худалдаа эрхлэгчийн хууль сахилттай харьцуулахад хяналтын түвшин хэт их байна.
- Онилгоог хангалттай түвшинд нарийвчлаагүй буюу нарийн тохируулаагүй байна.
- Хяналт бүрэн хэмжээнд чанартай хийгдэхгүй байна (биет үзлэг тус бүрийг гүйцэтгэж буй ажилтнуудын тоо цөөн).
- Биет үзлэгийн зорилгод нь залиланг илрүүлэх болон залилангийн эрсдэлээс үл хамааран Засгийн газрын бусад агентлагаас тавьж буй шаардлагын дагуу барааны төлөвийг баталгаажуулах гэсэн 2 асуудлыг холилдуулан оруулсан.
- Хяналтын үр дүнгийн тайлан хангалтгүй, үнэн зөв мэдээлэл өгч чадахгүй байна. Жишээ нь: байцаагч залиланг илрүүлсэн ч зохих ёсоор мэдээлж, тайлагнаагүй байх.

С. Биет үзлэгийн тоог бууруулах арга зам, зөвлөмж

7. 2024 оны эцэс хүртэлх богино цаг хугаанд биет үзлэгийн тоог бодитоор бууруулах арга зам хязгаарлагдмал байна. Энэ дэд хэсэгт санал болгож буй арга замуудыг ГЕГ-ын нь хууль тогтоомжийн мөрдөлтийн эрсдлийн удирдлагыг богино хугацаанд өөрчлөх боломжгүй гэсэн нөхцөлд авч үзсэн болно.


8. Тодорхойлсон хоёр үндсэн арга замыг зэрэг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд дараалан хэрэгжүүлэх шаардлагагүй болно. Нэгт, RI (болон EI) эрсдэлийн бүлгийн улаан төлөвт хуваарилах магадлал ихтэй параметрийг багасгах. Хоёрт, улаан төлөв давамгайлсан

эрсдэлийн бүлгийн сонголтын шалгуур (FSTIC, FSTIG, MI, and HI) -ыг бусад шалгуур (EI, RI and LI) -т шилжүүлэх зорилгоор эрсдэлийн бүлгийн сонголтын шалгууруудыг дахин хянаж, дахин инженерчлэх. Хоёр дахь арга зам бол HI эрсдэлийн бүлгийг устгаж, баримт бичгийн шалгалт заавал хийх (YI) гэсэн эрсдэлийн шинэ бүлгийг бий болгох. ГЕГ нь энэхүү өөрчлөлтийг хийх хэрэгцээ шаардлага байгааг олж харсны сацуу үе шаттай арга замаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

9. Санал болгож буй үе шаттайгаар хэрэгжүүлэх арга замыг дараах жагсаалтад харуулав. FSTIC болон FSTIG эрсдэлийн бүлгийн хувьд нийт биет үзлэгт нөлөөлөх жингийн хувьд их биш тул бусад буюу доорх эрсдэлийн бүлгүүдэд анхаарал хандуулж, шинэчлэлийг хийх шаардлагатай. Схем 2-т үе шаттай өөрчлөлтийг зураглан харуулсан болно. Нэмэлт тайлбаруудыг доорх догол мөрүүдээс харна уу.

- HI эрсдэлийн бүлэгт байгаа Засгийн газрын бусад агентлагуудад үл хамаарах шалгууруудыг MI эрсдэлийн бүлэгт шилжүүлэх.
- RI (мөн EI) эрсдэлийг бүлгийн улаан төлөвт хуваарилах магадлал ихтэй параметрийг хянаж, багасгах.
- “Баримт бичгийн шалгалт заавал хийх” (YI) гэсэн эрсдэлийн шинэ бүлгийг бий болгох.
- MI эрсдэлийн бүлэгт байгаа Засгийн газрын бусад агентлагуудын шалгууруудыг YI эрсдэлийн бүлэгт шилжүүлэх (шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын бусад агентлаг буюу хариуцсан агентлагт эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэхийг ятгах).
- Зарим хувь импортлогчийг MI эрсдэлийн бүлгээс YI бүлэгт шилжүүлэх.
- Зарим ГЕГ-ын зохицуулалттай барааг MI эрсдэлийн бүлгээс YI бүлэгт шилжүүлэх.
- Хууль сахилттай аж ахуйн нэгжийг MI эрсдэлийн бүлгээс YI бүлэгт шилжүүлэх.
- Хууль сахилт өндөртэй худалдаа эрхлэгч болон бага эрсдэл бүхий ачааг RI эрсдэлийн бүлгээс LI бүлэгт шилжүүлэх.

Схем 2. Үе шаттай өөрчлөлтийн зураглал



MI эрсдэлийн бүлгийн дүн шинжилгээ

10. ГЕГ нь эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тул дүрэмд суурилсан шалгуур үзүүлэлтэд (MI) тулгуурладаг байдлыг өөрчлөх цаг болсон байна. MI нь олон дэд ангилалтай, дэд ангилал тус бүр тодорхой дүрэмтэй холбоотой бөгөөд тэр дундаас хамгийн том дэд ангилал нь ЗГБА-ын зохицуулалттай бараа юм. ГЕГ-аас ЗГБА-ын зохицуулалттай барааг эрсдэл багатайд тооцдог бөгөөд импортлогч нь холбогдох ЗГБА-аас шаардлагатай лиценз, зөвшөөрөл авсан эсэхийг шалгах зорилгоор зөвхөн баримт бичгийн шалгалт хийх нь хангалттай гэж дүгнэсэн. Ажлын хэсгээс гаргасан тооцооллоор нийт импортын мэдүүлгийн 25 орчим хувь нь ЗГБА-ын зохицуулалттай хамааралтай бараа байгаа аж.¹

11. MI эрсдэлийн дэд ангилал дотроос дүн шинжилгээ хийж, хянах шаардлагатай дараагийн ангилал бол хууль сахилтаас үл хамааран импортын бараа нь улаан төлөвт хуваарилагдаж буй хувь хүмүүс юм. Монгол улсад хувь хүмүүсийн импортын нийт импортод эзлэх хувь харьцангуй өндөр байна. Цахим худалдааны шинэ тогтолцоог Монгол улсад нэвтрүүлэхээр яригдаж байна. Олон цахим худалдааны компаниудаас ачаа тээвэрлэлт болон борлуулалтын цогц дэлгэрэнгүй мэдээлэл авах нь зүйтэй. Ингэснээр эрсдэлийн дүн шинжилгээг оновчтой хийх, хууль сахилт сайтай, импортын давтамж өндөртэй хувь хүмүүсийг MI эрсдэлийн бүлгээс бусад эрсдэлийн бүлэг тэр дундаа LI эрсдэлийн бүлэгт шилжүүлэх боломжтой болно.

¹ 2022 оны 1-р сард МХЕГ-ын хилийн мэргэжлийн хяналтын чиг үүргийг ГЕГ-т нэгтгэсэн билээ. Харин биет үзлэгийн дунд хугацааны зорилтыг энэхүү үйл явцаас өмнө тодорхойлсон байна. ГЕГ нь МХЕГ-ын биет үзлэгийн сонголтыг удирдах бүрэн эрхтэй болох хүртэл МХЕГ-ын биет үзлэгийг тусад нь бүртгэх нь зүйтэй. Мөн CAIS систем дээр ЗГБА зохицуулалт, лицензийн дугаар зэрэгт хамаарах мэдүүлгийн мэдээлэл байхгүй байна.

12. Хянаж үзэх шаардлагатай 3 дахь дэд ангилал бол биет үзлэгт давтан хамрагдсан бараанууд юм. Импортын архи, тамхи нь ГЕГ-ын хатуу хяналтад байдаг баталгаат агуулахад хадгалагддаг.

ГЕГ-ын шаардлага хангасан, тусгай зөвшөөрөлтэй импортлогч компани ачааныхаа зарим хэсгийг баталгаат агуулахаас тээвэрлэхдээ барааны мэдүүлэг үйлдэх ба биет шалгалт хийгдэнэ. ГЕГ импортлогч болон импортын бараа нь давтагдаж байгаа учраас эдгээр импортын мэдүүлгийг эрсдэл багатай гэдгийг мэднэ. Түүнчлэн импортлогч болон баталгаат агуулахын аль аль нь бага эрсдэлтэй гаалийн харилцагч талууд юм. Давтагдсан мэдүүлгүүд ялангуяа зохицуулалттай/ тусгай зөвшөөрөлтэй импортлогчдын үйлдсэн мэдүүлгийг хянаж, дүн шинжилгээ хийж, MI эрсдэлийн бүлгээс бага эрсдэлийн бүлэгт шилжүүлэх хэрэгтэй².

13. Дараагийн дүн шинжилгээ хийх дэд бүлэг бол өнгөрсөн 3 жилд зөрчил гаргасан худалдаа эрхлэгчийн импортолсон бараа. Дүрмийн дагуу зөрчил гаргасан худалдаа эрхлэгч дараагийн 3 жилийн турш MI буюу заавал шалгах эрсдэлийн бүлэгт ангилагдана. Хэдийгээр хууль сахилтын түүхэд суурилсан эрсдэлийн үнэлгээг хийх нь зүйтэй ч зарим худалдаа эрхлэгчид эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, хууль сахилтаа сайжруулж болно. Эдгээр худалдаа эрхлэгчдийн эрсдэлийг тооцож, хууль сахилттай гэж үзвэл MI эрсдэлийг бүлгээс бага эрсдэлийн бүлэгт шилжүүлэхээр хянаж үзэх шаардлагатай.

Бусад эрсдэлийн бүлгийн дүн шинжилгээ

14. NI буюу өндөр эрсдэлийн бүлэг нь нийт импортын мэдүүлгийн хоёр дахь томоохон хувийг эзэлж байна. Өндөр эрсдэлийн бүлэг нь эрсдэлийн үнэлгээнд суурилсан бөгөөд MI эрсдэлийн бүлэг шиг нарийн дэд ангилалгүй. Өндөр эрсдэлийн бүлэгт эрсдэлийн үнэлгээг дахин хийх шаардлагатай бөгөөд цаг хугацаа их орох болно. Ажлын хэсгийн зүгээс NI эрсдэлийн бүлэгт хамгийн сүүлд дүн шинжилгээ хийж, хянахаар тооцоолсон байна. Энэхүү дүн шинжилгээний явцад богино хугацааны зөвлөх NI эрсдэлийн бүлгийг бусад эрсдэлийн бүлэгт нэгтгэн оруулах хувилбарыг судлах хэрэгтэй гэж зөвлөсөн.

15. EI эрсдэлийн бүлэг бол MI, NI эрсдэлийн бүлгүүдэд хамаарахгүй онцгой бараа бөгөөд RI эрсдэлийн бүлгээс эрсдэл багатайд тооцогддог. Эрсдэлийн үнэлгээнд суурилсан тохиргоотой. EI эрсдэлийн бүлэг нь RI болон LI эрсдэлийн бүлгийн дундуур өөрийн гэсэн параметртэй байх шаардлагатай бөгөөд одоогийн параметр нь RI эрсдэлийн бүлгийнхтэй адил байна. EI эрсдэлийн бүлгийн улаан төлөвт хуваарилах магадлал ихтэй параметр нь 40 хувиас 10 хувь хүртэл буурах төлөвтэй байна. Биет үзлэгт эзлэх хувь хэмжээ бага, мөн шинэчлэл хийх төлөвлөгөө зэргийг харгалзан бусад эрсдэлийн бүлэгт дүн шинжилгээ хийхийг илүү чухалчлах нь зүйтэй.

² Автомашин давтан импортлогчдод анхаарал хандуулах шаардлагатай. Учир нь ийм бизнесийн загвар нь гаалийн үнэлгээний асуудлууд тухайлбал холбогдох талуудын хоорондын худалдаа, борлуулалт, хуучин автомашины үнэлгээ зэрэг асуудлуудыг тээж байдаг.

16. ГЕГ-аас гаалийн итгэмжлэгдсэн ААН-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхээр LI эрсдэлийн бүлгийн тоо ихсэх төлөвтэй байна. Итгэмжлэгдсэн ААН-ийн импортыг LI эрсдэлийн бүлэгт тооцохоор төлөвлөж байна.

17. RI эрсдэлийн бүлэг нь бусад эрсдэлийн бүлэгт хамаарахгүй бүлэг бөгөөд “түүврийн сонголт” биш юм. RI эрсдэлийн бүлэгт скрининг хийх буюу шалгах механизм байхгүй бөгөөд хуваарилалтын харьцаа нь аль нэг хяналтын төлөвийг санамсаргүйгээр сонгодог байна.

Баримт бичгийн шалгалт заавал хийх (YI) гэсэн эрсдэлийг бүлгийг шинээр бий болгох

18. Ихэнх биет үзлэг шалгалтыг баримт бичгийн баталгаажуулалтаар солих боломжтой ба солих нь зүйтэй юм. Биет үзлэгээр барааны тоо хэмжээ, ангиллыг шалгах боломжтой боловч бага үнээр мэдүүлсэн мэдүүлгийг илрүүлэх боломж нь баримт бичгийн баталгаажуулалтаас сул юм. Мөн импортын шаардлага хангасан эсэхийг баримт бичгээр (ЗГБА-аас олгосон лиценз) шалгахаас гадна бараанд биет үзлэг хийх шаардлагагүй MI эрсдэлийн бүлэгт хамаарч буй бараа олон байна. Тиймээс шинэ шалгуур үзүүлэлттэй болох нь зүйтэй. ГЕГ нь MI болон NI эрсдэлийн бүлгийг дахин дүн шинжилгээ хийж, нэгтгэж, YI гэсэн шинэ эрсдэлийн бүлгийг нэвтрүүлэхээр хэлэлцэж байна. Мөн газар дээр нь ажиллаж буй ажилтан, байцаагч нарын мэдлэг, туршлагыг шингээсэн (YI+) удирдамж, стандарт үйл ажиллагааны журам (СҮАЖ) боловсруулахаар хэлэлцэж байна. Гэвч ийм механик үйл ажиллагааг түр зуурын арга хэмжээнд тооцох шаардлагатай бөгөөд хувь хүний дүгнэлтээр сонголт хийх нөхцөлд хүргэхгүй байх шаардлагатай. Мөн өндөр түвшний хариуцлагатай байхыг шаарддаг. Одоогоор CAIS системд автомат сонголт хийдэг функц байхгүй ч цаашид хөгжүүлэх, бий болгох нь зүйтэй.

D. Эрсдэлийн удирдлагын урт хугацааны шинэчлэл

19. Урт хугацааны шинэчлэлийн хувьд орчин үеийн гаалийн эрсдэлийн удирдлагад нийцүүлэхийн тулд одоогийн хууль тогтоомжийн мөрдөлтийн эрсдэлийн удирдлагыг шинэчлэх шаардлагатай. Энэ нь CAIS системийг шинэчлэх шаардлагатай гэсэн үг юм. Одоогийн загварын зарчим нь санамсаргүй шалгах параметр бүхий сугалааны систем дээр суурилдаг бөгөөд долоон сугалааны систем байдаг. Сонголт хийх функц нь мэдүүлгийг сугалааны системийн аль нэгэнд хуваарилах үүрэгтэй. Түүнчлэн бага (өндөр) үнэ бүхий мэдүүлгийг хянах сонголтын шалгуур зэрэг олон улсын жишиг сонголтын шалгуурууд CAIS системд байдаггүй. Олон улс оронд аюулгүй барааны хувьд тухайн бараа (эсвэл тухайн экспортлогч улсын хослол) -ны нэгж үнийн мэдээллийг хүснэгтэд бүртгэдэг бөгөөд хэрэв мэдүүлсэн үнэ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс доогуур (жишээ нь барааны жишиг нэгж үнийн мэдээллээс 20 хувиар бага) байвал систем энэхүү мэдүүлгийг баримт бичгийн (нэхэмжлэх, тээврийн баримт, төлбөрийн баримт эсвэл дүрэм журмын дагуу гаалийн байгууллагаас шаарддаг бусад баримт бичиг) шалгалтаар оруулахаар сонгоно. Иймээс мэдүүлгийн бүх

өгөгдлийн элементүүд ба тэдгээрийн хослол болон зохих журмын дагуу хөтөлсөн өгөгдлийн хүснэгт (нэгжийн үнэ, хууль сахилтын оноо, залилангийн магадлал өндөртэй бараа зэргийг багтаасан) -ийг сонголтын шалгуур болгон ашиглаж болно.

20. ГЕГ хилийн боомтын хяналтын үр дүнгийн тайлагналыг 100 хувьд хүргэхийн тулд удирдлагын түвшинд хүчин чармайлт гаргах ёстой. Сонголтын шалгуурыг сайжруулах нь эрсдэлд суурилсан хяналтыг амжилттай хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай элемент бөгөөд үүний тулд хяналтын үр дүнгийн тайлан болон зөрчлийн тайланг үнэн зөв, цаг тухайд нь гаргах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү тайлангийн мэдээлэл нь сонголтын шалгуурыг нарийн тодорхойлох, онилгоог сайжруулахад туслах болно. Нөхцөл байдлыг ГЕГ-ын удирдлагад сар тутам мэдээлж байх шаардлагатай бөгөөд хэрэв тайлагналын түвшин бага байвал удирдлагын зүгээс арга хэмжээ авч ажиллах шаардлагатай. Энэ нь ГЕГ-ын нөөцийг ашиглах хариуцлага, түүнчлэн гүйцэтгэл, ёс зүйн хангалттай түвшинг хангах чиг үүрэгт хамаарах юм. Үүнийг байгууллагын эрсдэлийн удирдлагын асуудал гэж ойлгож болно.

ГЕГ-ын ажилтнууд баримт бичгийн шалгалтыг төдийлөн хийдэггүй бөгөөд СҮАЖ болон түүнийг хэрэгжүүлэхэд туслах арга механизм, өөрчлөлтийн менежмент, сургалт зэрэг нь нэн шаардлагатай байна.

21. ГЕГ хяналтын үр дүнгийн тайлангналын түвшин 100 хувь болох үед хяналтын үр дүнгийн тайлангийн агуулгыг сайжруулахад анхаарах шаардлагатай.

Одоогийн биет үзлэгийн тайлан нь гурван мэдээллийн хэсгээс бүрддэг бөгөөд энэ нь эрсдэлийн дүн шинжилгээ хийхэд хангалтгүй юм. Барааг шалгаж буй байцаагч тухайн барааг биет үзлэгт хамруулахаар сонгосон шалтгааныг мэдэж байх ёстой бөгөөд хяналтын үр дүнгийн тайланд бусад дүгнэлтийг оруулж болохоос гадна энэхүү шалтгааныг үргэлж тусгаж оруулсан байх ёстой. Хяналтын үр дүнгийн тайлангийн агуулгын загварыг дараарх нэмэлт мэдээлэл 1-т харуулав.

Нэмэлт мэдээлэл 1. Хяналтын үр дүнгийн тайлангийн агуулгын загвар

- Мэдүүлгийн дугаар
- Шалгалтын шалтгаан, кодоор
- Шалгалтын төрөл, кодоор
- Шалгалтын өдөр
- Импортлогчийн код, экспортлогч/тээвэрлэгчийн код, гаалийн зуучлагчийн код, гарал үүслийн улс, тээврийн хэрэгслийн код, ачааны төрлийн код зэргийг мэдүүлгийн дугаараар татаж авах боломжтой байх.
- Шалгалт үргэлжлэх хугацаа
- Шалгалт хийж буй байцаагч нарын тоо
- Гэрч, кодоор
- Үр дүн, кодоор

III. ДАРААГИЙН АЛХМУУД

22. ГЕГ хилийн боомтын хяналтын үр дүнгийн тайланг нэгтгэн дүгнэж, биет үзлэгийг бууруулах арга хэмжээ авч, энэхүү тайланд дурдсан түр арга хэмжээг баталгаажуулах шаардлагатай. Сүүлийн арга хэмжээний хувьд дараах үе шаттай арга хэмжээг авахыг зөвлөж байна. Үүнд:

Эхний үе шатын зорилго (Импортын мэдүүлгийн 82 хувьд биет үзлэг хийх)

- RI, EI эрсдэлийг бүлгийн улаан төлөвт хуваарилах магадлал ихтэй параметрийг багасгах.
- NI болон MI эрсдэлийн бүлэгт байгаа Засгийн газрын бусад агентлагуудтай холбоотой тохиргоог устгах.
- Итгэмжлэгдсэн ААН-ийн тохиргоог боловсруулж эхлэх.
- Биет үзлэгийн тайлан болон зөрчлийн тайланд зориулж стандарт үйл ажиллагааны журам (СҮАЖ) боловсруулах.
- МХЕГ-ийн нэгтгэсэн чиг үүргийн нөлөөнд дүн шинжилгээ хийж эхлэх.

Хоёр дахь үе шатын зорилго (Импортын мэдүүлгийн 60 хувьд биет үзлэг хийх)

- NI эрсдэлийн бүлгийн бүх тохиргоог MI эрсдэлийн бүлэг рүү шилжүүлэх.
- NI эрсдэлийн бүлгийг YI болгон өөрчлөх (эсвэл NI эрсдэлийн бүлгийг устгаж, YI эрсдэлийн бүлгийг шинээр үүсгэх).
- YI эрсдэлийн бүлэгт улаан төлөвт хуваарилах магадлал ихтэй параметрийг оруулах, MI болон NI эрсдэлийн бүлгээс устгасан ЗГБА-тай холбоотой тохиргоог YI эрсдэлийн бүлэгт оруулах
- Итгэмжлэгдсэн ААН-ийн тохиргоог LI эрсдэлийн бүлэгт оруулах.
- MI болон NI эрсдэлийн бүлгийн дүрэмд суурилсан тохиргоог устгаж эхлэх.
- Хилийн боомтуудаас хяналтын үр дүнгийн тайлан ирүүлсэн байдалд дүн шинжилгээ хийж, тайлагналтын түвшин бага байгаа хилийн боомтуудын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах.
- Шинэчилсэн биет үзлэгийн тайлан, зөрчлийн тайлан зэргийг ашиглан шалгуур үзүүлэлтүүд болон биет үзлэгт дүн шинжилгээ хийж эхлэх.
- Зарим хувь хүмүүс болон хууль сахилтын түвшин сайжирсан компаниудын эрсдэлд дүн шинжилгээ хийж эхлэх.
- MI болон NI эрсдэлийн бүлэг дэх хууль сахилттай хувь хүн, компаниудын тохиргоог устгаж эхлэх.
- Механик буюу гараар шалгах шалгуур бүхий СҮАЖ-ыг боловсруулж эхлэх.

Гурав дахь үе шатын зорилго (Импортын мэдүүлгийн 50 хувьд биет үзлэг хийх)

- YI, RI, EI эрсдэлийн бүлгийн улаан төлөвт хуваарилах магадлал ихтэй параметруудийг багасгах.
- MI, NI эрсдэлийн бүлгээс устгасан тохиргоог YI эрсдэлийн бүлэг рүү шилжүүлэх

- Шинэ СҮАЖ-аар гараар шалгах шалгуур болон YI+ эрсдэлийн бүлгийг ажиллуулж эхлэх.
- Гараар шалгах шалгуурыг баталгаажуулж шалгах, эрсдэл багатай бүлгийг тодорхойлох.
- YI эрсдэлийн бүлгээс эрсдэл багатай бүлгийн тохиргоог устгах.
- СҮАЖ болон гараар шалгах шалгуурын биет үзлэгийн харьцаанд дүн шинжилгээ хийх.

Дөрөв дэх үе шатын зорилго (Импортын мэдүүлгийн 40 хувьд биет үзлэг хийх)

- YI, LI, RI, EI эрсдэлийн бүлгийн улаан төлөвт хуваарилах магадлал ихтэй параметруудийг багасгах.
- YI эрсдэлийн бүлгээс устгасан тохиргоог LI эрсдэлийн бүлэг рүү шилжүүлэх
- Биет үзлэгийн түвшинг баталгаажуулан шалгах.
- Шаардлагатай бол бусад эрсдэлийн бүлгийн улаан төлөвт хуваарилах магадлал ихтэй параметруудийг бууруулахад бэлтгэх.